



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөнгөлөлттэй зээл нь хоршооны үйл ажиллагааг дэмжих үндсэн зорилтоо хангаагүй боловч малчин иргэдийн амьдралд эерэг үр дүнг үзүүлсэн байна.

АУДИТЫН СЭДЭВ: “ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН”-д ОЛГОСОН ЗЭЭЛ, ЭРГЭН ТӨЛӨЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СЭА-2026/21/17-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум	Дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх	
	Утас: 70363040	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
2026 он	Аудитын менежер	Т.Болор
	Утас: 70363036	Цахим хаяг: Bolort@audit.gov.mn
	Аудитор	Ж.Цогт
	Утас: 70363047	Цахим хаяг: Tsogtj@audit.gov.com
	Аудитор	Б.Наранцэцэг
	Утас: 70363036	Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар	1
Хүснэгтийн товъёг	2
Дүрслэлийн товъёг	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	2
Ерөнхий мэдээлэл	4
1 бүлэг: Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан шалгуур үзүүлэлт, санхүүжилтийг бүрэн, бодитой төлөвлөөгүйгээс хэрэгжилтийн үр нөлөө төлөвлөсөн түвшинд хүрээгүй байна.	5
1.1 “Шинэ хоршоо – чинээлэг малчин арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан арга хэмжээний хүрэх түвшин шаардагдах хөрөнгийг бодитой тооцоогүй байна.	5
2 бүлэг: Зээлийн шалгуур нь хоршоонд биш, хувь малчинд чиглэсэн нь малчдыг хамтын бизнес рүү биш, зөвхөн зээл авахын тулд бичиг баримтын нэгдэл буюу хэлбэр төдий хоршоо байгуулсан байна.	7
2.1. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоод нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан боловч хуулийн хугацаанд санхүүгийн тайлан, бүртгэл хөтлөлт хангалтгүй байгаа нь үйл ажиллагааны үр дүнг бодитой үнэлж, дүгнэх боломжгүй байдалд хүргэж байна.	7
2.2. Банкны шалгуур хангасан малчдад хөнгөлөлттэй зээлийг олгосон хэдий ч зээлийн зарцуулалт, ашиглалт болон эргэн төлөлтийн явцад үр нөлөө бүхий хяналтыг холбогдох байгууллагуудаас хийгээгүй байна.	10
Илрүүлсэн зөрчил	15
Дүгнэлт	16
Зөвлөмж	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс

Хүснэгтийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хоршоодын санхүүгийн тайлангийн мэдээлэл	9
Хүснэгт 2	Хоршоод олгосон зээлийн мэдээлэл	10
Хүснэгт 3	Хоршоод хяналт хэрэгжүүлсэн байдал	12

Дүрслэлийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Ерөнхий гэрээнд оролцогч арилжааны банкнууд	5
Дүрслэл 2	“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий нээлт	6
Дүрслэл 3	Хоршооны болон гишүүдийн тооны өсөлт	7
Дүрслэл 4	Хоршооны тухай хуулийн хэрэгжилт	8
Дүрслэл 5	Зээл хүсэгчид тавигдах шаардлага	10
Дүрслэл 6	Мал бүхий иргэдэд олгосон зээлийн мэдээлэл	11
Дүрслэл 7	Зээлийн эргэн төлөлт	11
Дүрслэл 8	Зээлийн хугацаанаас өмнө төлөлтийн мэдээлэл	13
Дүрслэл 9	“Шинэ хоршоо хөдөлгөөн”-р бий болсон бүтээн байгуулалтууд	15

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар “Аудитын сэдэв батлах тухай” тогтоолоор баталсан Төрийн аудитын байгууллагын 2026 оны гүйцэтгэх аудитын сэдэв, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2026 оны А/174 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө” болон Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Засгийн газрын 2024 оны 166 дугаар “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай тогтоолын хүрээнд малчинд олгосон зээл, эргэн төлөлт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, санал дүгнэлт өгөхөд аудитын зорилго оршлоо. Уг зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: ➤ Төрөөс шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх чиглэлээр тодорхойлсон хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх, ➤ Хоршоог хуульд заасан шаардлагын дагуу байгуулж, олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж, үр дүнг тооцож байгаа эсэх.
Аудитын хамарсан хүрээ:	Аймаг, сумын Засаг дарга, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Төрийн банк, Хаан банк, Хас банк болон шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 2024-2025 онд зээл авсан 378 хоршооны 1126 малчдыг хамруулан, 2024-2025 оны зээлийн

	хувийн хэрэг, мэдээллийг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй:	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 3000, 4000, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит.Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудит”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг ашиглан холбогдох байгууллагаас ирүүлсэн судалгаа, мэдээлэл, эрх бүхий байгууллагын хяналтын тайлан, цахим болон цаасан суурьтай нотлох баримтад үндэслэн асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаа мэдээллийг нягтлан шалгаж, нэгтгэх, харьцуулах, тооцоолох, дүн шинжилгээ хийх зэрэг горим, арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглалаа.Үүнд: • Төрийн аудитын тухай хууль, • Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль, • Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль, • Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль • Хоршооны тухай хууль, • Иргэний хууль • Банкны тухай хууль • Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль. • УИХ-ын 2021 оны 106 дугаар “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” тогтоол, • ЗГ-ын 2024 оны 166 дугаар “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай тогтоол, • Сангийн сайдын 2022 оны А/155 дугаар тушаалаар баталсан Хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам, • “Хоршооны гишүүн малчны зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээ” 2024 оны 240509/84, 240508/03-372, 1824/173 дугаар гэрээ, • ЗГ-ын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах” журам, • Холбогдох бусад захиргааны хэм хэмжээний акт
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх удирдаж, аудитын менежер Т.Болор явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, аудитор Ж.Цогт, Б.Наранцэцэг, Ж.Баясгалан, Э.Энхбүрэн, Р.Отгонжаргал нар 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:	“Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Засгийн газрын 166 дугаар “Шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлэх тухай” тогтоолыг баталсан байна. Уг тогтоолоор банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх хоршооны гишүүн малчинд олгох 5 хүртэл жилийн хугацаатай зээлийн 6 хувийн хүүгээс давсан хүүгийн төлбөрийг Засгийн газраас хариуцан төлөхөд батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар 2025-2033 онуудад шаардагдах эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэхээр заасан байна. Сэлэнгэ аймагт нийт 1,126 зээлдэгчид 39,236.2 сая төгрөгийн зээл олгосноос Төрийн банк 770 зээлдэгчид 27,950.9 сая төгрөгийн буюу нийт олгосон зээлийн 71.2 хувийг дангаар олгосон бол Хаан банк 11,060.6 сая төгрөгийн, Хас банк 224.7 сая төгрөгийн зээл олгож, бусад банк нь огт зээл олгоогүй байна.
------------------------------	--

Бүлэг 1

Төрөөс шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх чиглэлээр тодорхойлсон хөтөлбөр үр дүнд суурилан боловсруулагдаж, хэрэгжиж байна уу?

Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан шалгуур үзүүлэлт, санхүүжилтийг бүрэн, бодитой төлөвлөөгүйгээс хэрэгжилтийн үр нөлөө төлөвлөсөн түвшинд хүрээгүй байна.

1.1 “Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” тогтоолд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, санхүүжилтийг бодитой бүрэн тусган төлөвлөж, хэрэгжүүлж байна уу?


“Шинэ хоршоо – чинээлэг малчин арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан арга хэмжээний хүрэх түвшин шаардагдах хөрөнгийг бодитой тооцоогүй байна.

1.1.1 Уламжлалт мал ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр УИХ-аас соёрхон баталж, 04 дүгээр сарын 24-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байна.

1.1.2 Дээрх хуулийг үндэслэн Засгийн газраас мал аж ахуйн салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх, малчдыг хоршооны зохион байгуулалтад нэгтгэх, малын гаралтай түүхий эдийн боловсруулалт, үйлдвэрлэлийг дэмжих, улмаар малчдын орлого, амьжиргааг дээшлүүлэх зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 166 дугаар тогтоолоор “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээг өрнүүлэх тухай тогтоол баталсан байна.

1.1.3 Уг тогтоолын дагуу Сангийн яам нь арга хэмжээний хүрээнд олгох хөнгөлөлттэй зээлийг хоршооны малчдад олгох зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монгол банк, Зээлийн батлан даалтын сан болон арилжааны банкнуудтай ерөнхий гэрээ байгуулсан байна. Ерөнхий гэрээнд оролцогч арилжааны банкнуудыг хүснэгтээр харуулбал:

Дүрслэл 1. Ерөнхий гэрээнд оролцогч арилжааны банкнууд



“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

1.1.4 Тус ерөнхий гэрээнд “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 2,750 малчин өрхийг хамруулж, 500,000.0 сая төгрөг хүртэлх хэмжээний хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг арилжааны банкнууд өөрийн эх үүсвэрээр олгож, зээлийн хүүгийн хөнгөлөлтийг төрөөс санхүүжүүлэхээр тусгасан боловч санхүүжилтийг аймаг, орон нутгийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан хуваарилалт хийгээгүй байна.

1.1.5 Сэлэнгэ аймагт нийт 1,126 зээлдэгчид 39,236.2 сая төгрөгийн зээл олгосноос Төрийн банк 770 зээлдэгчид 27,950.9 сая төгрөгийн буюу нийт олгосон зээлийн 71.2 хувийг дангаар олгосон бол Хаан банк 11,060.6 сая төгрөгийн, Хас банк 224.7 сая төгрөгийн зээл олгож, бусад банк нь огт зээл олгоогүй байна.

1.1.6 Тайлант онуудад Төрийн банк, Хаан банкнуудын зээлийн эх үүсвэр тодорхой хугацаанд хүрэлцэхгүй болж, зээл олголт түр саатсан нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн хэрэгцээ, банкнуудын эх үүсвэрийн боломж, оролцооны түвшинг бодитой тооцоогүйг харуулж байна.

1.1.7 Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар болон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас ажлын хэсэг байгуулан сум, хоршоодод мэдээлэл хүргэх, сургалт зохион байгуулах, хоршооны хөнгөлөлттэй зээлд хамруулах ажлыг зохион байгуулсан байна.

Дүрслэл 2. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий нээлт



1.1.8 Мөн “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд шинээр байгуулагдсан хоршоодыг чадавхжуулах төвийн бүсийн сургалтыг Дархан-Уул аймагт зохион байгуулж, хоршоодын удирдлага, гишүүдийг хамруулан сургалт арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

1.1.9 Тус хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл, хэрэгжилтийг долоо хоног бүрийн мягмар, пүрэв гарагт цахим хэлбэрээр олон нийтэд нээлттэйгээр мэдээлэл өгч ажиллажээ.

1.1.10 Хэрэгжилтийн явцад Зээлийн батлан даалтын сан болон арилжааны банкнуудтай хамтран зээлийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлтийн байдалд хяналт тавьж, хэрэгжилтийн мэдээллийг нэгтгэн тайлагнаж ажилласан байна.

1.1.11 Гэвч аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар нь малчдад мэдээлэл хүргэх, зээлд хамруулах, хэрэгжилтийн мэдээллийг нэгтгэн тайлагнах чиг үүргээ хэрэгжүүлсэн боловч санхүүжилтийн хүндрэл, банкнуудын оролцоо, зээлийн эх үүсвэрийн хүрэлцээгүй байдлыг арилгахад чиглэсэн зохицуулалт, үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Бүлэг 2

Хоршоог хуульд заасан шаардлагын дагуу байгуулж, олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж, үр дүнг тооцож байна уу?

Хоршоонд бус малчинд чиглэсэн зээлийн бодлого, шалгуур үзүүлэлтийн дутагдалтай байдлаас үүдэн зээлийн шаардлага хангах зорилготойгоор нэгдсэн хэлбэр төдий анхан шатны хоршоодыг бий болгосон байна.

2.1. Холбогдох хуулийн дагуу хоршоо нь шинээр үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа нь тайлагнагдаж байна уу?

Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоод нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан боловч хуулийн хугацаанд санхүүгийн тайлан, бүртгэл хөтлөлт хангалтгүй байгаа нь үйл ажиллагааны үр дүнг бодитой үнэлж, дүгнэх боломжгүй байдалд хүргэж байна.

2.1.1 Хоршооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Хоршоог үүсгэн байгуулагчид хоршоо үүсгэн байгуулах талаар гэрээ байгуулж, уг гэрээнд хоршооны зорилго, үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээ, эрх, үүрэг, хариуцлага зэргийг тусгана”, 8.2-т “Хоршоог улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсгэн байгуулах гэрээ дуусгавар болно гэж заасан” гэж тус тус заасан байдаг.

2.1.2 Сэлэнгэ аймгийн хэмжээнд нийт 709 хоршоо бүртгэлтэй байгаа бөгөөд үүнээс “Шинэ хоршоо хөдөлгөөн” хэрэгжиж эхэлсэн 2024 оноос хоршооны тоо огцом өссөн байна. Үүнд: 2023 онд 204, 2024 онд 600, 2025 онд 709 хоршоо бүртгэгдсэн бол гишүүдийн тоо мөн хугацаанд 4,668-аас 9,207 болж нэмэгдсэн байна.

Дүрслэл 3. Хоршооны болон гишүүдийн тооны өсөлт



2.1.3 Аймгийн хэмжээнд бүртгэлтэй 709 хоршооны 53.3 хувь буюу 378 хоршооны гишүүн болох малчин иргэд тус хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна.

2.1.4 Аудитаар хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 378 хоршооны үүсгэн байгуулах гэрээг авч үзэхэд тус гэрээнд үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээ, эрх үүрэг, хариуцлагыг бүрэн тусгасан байна.

2.1.5 Аудитад хамрагдсан бүх хоршоо анхан хэлбэртэй байгаа бөгөөд эдгээрийн 345 буюу 91.3 хувь нь 2024–2025 онд буюу “Шинэ хоршоо хөдөлгөөн” хэрэгжих хугацаанд шинээр байгуулагдсан байна. Нийт гишүүдийн тоо 4,266 бөгөөд нэг хоршоо 9-өөс 302 хүртэлх гишүүнтэй байна. *Дүрслэл 4. Хоршооны тухай хуулийн хэрэгжилт*

2.1.6 Хоршооны тухай хуульд хоршоог үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээ, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх тухай дараах заалтууд тусгагдсан байна.



2.1.7 Аудитад хамрагдсан 378 хоршоо нь улсын бүртгэлд бүрэн бүртгэгдсэн бөгөөд дүрэмдээ гишүүдийн оруулах хувь хөрөнгийн хэмжээг тусган баталсан байна. Тухайн хоршоодын дүрмийн сангийн нийт хөрөнгийн хэмжээ 864.5 сая төгрөг буюу 0.009-67.5 сая төгрөг хүртэл байна.

2.1.8 Аудитаар аймгийн Улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн хоршоодын дүрмийн санг үнэн зөв тусгасан эсэхийг тулган баталгаажуулахад дараах 2 хоршооны дүрмийн санг зөрүүтэй бүртгэсэн байна.

- Мандал сумын Тарни дээж сүү хоршооны дүрмийн санг 4.5 сая төгрөгийг 4,500.0 сая төгрөг гэж 4,495.5 сая төгрөгөөр илүү,
- Мандал сумын Цэлмэгийн түмэн сүрэг хоршооны дүрмийн санг 36.0 сая төгрөгийг 36,000.0 сая төгрөг гэж 35,964.0 сая төгрөгөөр илүү,

2.1.9 Энэ нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл оруулах, өөрчлөх, боловсруулах, баталгаажуулах ажлыг улсын бүртгэгч эрхлэн гүйцэтгэнэ”, 11.2-т “Улсын бүртгэгч цахим мэдээллийн санд мэдээллийг эх нотлох баримт бичигт үндэслэж, улсын бүртгэлийн байгууллагаас зөвшөөрөгдсөн программ хангамж, тоног төхөөрөмжийг ашиглан үнэн зөв оруулна” гэж заасантай нийцэхгүй байна.

2.1.10 Хоршооны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Хоршооны тухайн жилийн борлуулалтын нийт орлогын 20 хүртэл хувийг болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилна”, 25.2-т “Болзошгүй эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийг хоршооны санхүүгийн тогтвортой байдлыг хангах, алдагдлыг нөхөх, эрсдэлийг

бууруулахад ашиглана”, 25.3-т “Болзошгүй эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалтаар ашиглаж үл болно”, 25.4-д “Болзошгүй эрсдэлээс хамгаалах санд заавал байлгах хөрөнгийн хэмжээ нь хоршооны сүүлийн гурван жилийн борлуулалтын орлогын дунджийн 20 хувиас хэтрэхгүй байна”, 27 дугаар зүйлийн 27.1-д “Хоршооны хөгжил, хоршооны гишүүний нийгэм, эдийн засгийн байдлыг дээшлүүлэх, амьдралын чанар, амьдрах орчныг сайжруулах зорилгоор хоршоо хөгжлийн сантай байж болно” гэж тус тус заасан байна.

2.1.11 Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоодын дүрэмд “**Хоршоо хөгжлийн сан**”-тай байж болно, “**Болзошгүй эрсдэлээс хамгаалах сан**”-г тухайн жилийн борлуулалтын орлогын 1-50 хувиар байгуулж ажиллана гэж тусгасан хэдий ч 2025 оны байдлаар дээрх сангуудад хөрөнгө төвлөрүүлээгүй байна. (дэлгэрэнгүйг хоршооны ерөнхий мэдээлэл судалгаанд харуулав.)

2.1.12 Зээлд хамрагдсан хоршоодын санхүүгийн тайланг тулган баталгаажуулахад 2024 онд 18 хоршоо 1,989.5 сая төгрөгийн, 2025 онд 9 хоршоо 6,798.6 сая төгрөгийн борлуулалтын орлого тус тус тайлагнасан боловч дээрх хоршоод нь Хоршооны тухай хууль болон хоршооны дүрэмд заасан болзошгүй эрсдэлээс хамгаалах санд орлогын тодорхой хувиар хөрөнгө байршуулах заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.1.13 Хөнгөлөлттэй зээлийг үйл ажиллагаа явуулж буй хоршоодод бус хоршооны гишүүн малчинд олгох үндсэн шалгуураас үүдэн малчид зээлд хамрагдах зорилгоор хэлбэр төдий хоршоо шинээр байгуулах нөхцөл бий болгосон байна. Үүний улмаас малчид хоршоолох хэлбэрээр хамтран ажиллах, бизнес төлөвлөгөөг бодитоор хэрэгжүүлэх үйл явц хангалтгүй байна.

2.1.15 Хоршооны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Хоршооны хөрөнгө, эх үүсвэрийг энэ хуульд заасан журам, заавар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэнэ”, 34 дугаар зүйлийн 34.6-д “Тэргүүлэгчид хоршооны нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн байдалд хяналт тавьж, жилийн санхүүгийн тайланг Хяналтын зөвлөлд танилцуулж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлнэ”, Сангийн сайдын 2022 оны А/155 дугаар тушаалаар батлагдсан “Хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам”-ын “Ерөнхий зүйл”-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг хоршооны Тэргүүлэгчид хүлээнэ” гэж заасан байна.

2.1.16 Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан нийт 378 хоршооноос 2024 онд 184, 2025 онд 120 хоршоо нь ebalance.mof.gov.mn цахим системд санхүүгийн тайланг шивээгүй байна. Тодруулбал:

Хүснэгт 1. Хоршоодын санхүүгийн тайлангийн мэдээлэл

Хоршооны		Үүнээс:					
Байгуулагдсан он	Тоо	Тайлан гаргаагүй		Үйл ажиллагаа явуулаагүй		Борлуулалтын орлого тайлагнасан	
		2024	2025	2024	2025	2024	2025
2003-2023	33	14	13	16	17	3	3
2024	298	170	96	113	196	15	6
2025	47	-	11	-	36	-	-
Нийт	378	184	120	129	249	18	9

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

2.1.17 Үүнээс харахад хоршоодын санхүүгийн тайлан, бүртгэл хөтлөлт хангалтгүй, үйл ажиллагааны үр дүнг бодитой үнэлж, дүгнэх боломжгүй байна.

2.1.18 Зөрчлийн тухай хуулийн 11.18 дугаар зүйлийн 1.17-д “*нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргаагүй,*” заасны дагуу зөрчил гаргасан хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 4,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан хэдий ч аймгийн хэмжээнд тайлан мэдээ ирүүлээгүй хоршоодод хариуцлагын ямар нэг арга хэмжээ авагдаагүй байна.

2.2. Хоршооны малчдад олгосон хөнгөлөлттэй зээлийг шалгуур хангасан малчинд олгож, үр дүнг хянаж байна уу?

Банкны шалгуур хангасан малчдад хөнгөлөлттэй зээлийг олгосон хэдий ч зээлийн зарцуулалт, ашиглалт болон эргэн төлөлтийн явцад үр нөлөө бүхий хяналтыг холбогдох байгууллагуудаас хийгээгүй байна.

2.2.1 “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 3.1 дүгээр хэсэгт зээл хүсэгчид тавих шаардлагыг тодорхой заасан байна. Үүнд:

Дүрслэл 5. Зээл хүсэгчид тавигдах шаардлага



2.2.2 Сэлэнгэ аймгийн хэмжээнд “Хоршооны гишүүний малчны зээл”-ийг 17 суманд 1,126 зээлдэгчид 39,236.2 сая төгрөгийн зээлийг Хаан банк, Төрийн банк, Хас банкнууд олгосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Хоршоод олгосон зээлийн мэдээлэл

№	Банкны нэр	Зээлд хамрагдсан хоршооны тоо	Зээлд хамрагдсан малчны тоо	/сая төгрөг/ Зээлийн дүн
1	Хаан банк	144	349	11,060.6
2	Төрийн банк	233	770	27,950.9
3	Хас банк	1	7	224.7
Нийт дүн		378	1126	39,236.2

2.2.3 Арилжааны банкнууд нь зээл хүсэгчид тавих шалгуур, хоршооны гишүүн малчин байх, үндсэн зээлдэгчийн нэр дээр мал тооллогод хамрагдсан байх гэснийг “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний дагуу Төрийн

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-ийн “Малчны тодорхойлолт”-оор мөн “Мал тооллогын бүртгэл”-ийн лавлагаагаар тодорхойлно гэсний дагуу материалыг бүрдүүлж зээл олгосон байна.

2.2.4 Аудитаар аймгийн Статистикийн хэлтсээс ирүүлсэн мэдээллээр мал тооллогын санг нарийвчлан тулгахад нийт 1,126 зээлдэгчээс 80 зээлдэгч нь мал бүхий иргэн байгаа бөгөөд тэдгээрт 2,266.2 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Үүнийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 6. Мал бүхий иргэдэд олгосон зээлийн мэдээлэл



2.2.5 Төрийн үйлчилгээний нэгдсэн /E-Mongolia/ системээс гарч буй “Малчны тодорхойлолт нь “Малчин” (мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэн) болон “Мал бүхий иргэн” (мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнээс бусад малыг өмчилж байгаа этгээд) хоёрын мэдээллийг зааглаж чадахгүй байна. Энэхүү зааг ялгаагүй байдал нь шалгуур хангаагүй хоршооны гишүүнд хөнгөлөлттэй зээл олгох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.2.6 Арилжааны банкнууд (Төрийн банк, Хаан банк, Хас банк) нь Монгол банкны “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу зээлийн эргэн төлөлтийн хугацааг сар, улирал тутамд хянах бөгөөд хугацаа хэтэрсэн хоногоор нь зээлийн чанарыг ангилсан байна.

2.2.7 “Хоршооны гишүүний малчны зээл”-ийн хуваарийн дагуу төлбөл зохих, төлсөн зээлийн дүн, зээлийн үлдэгдлийн мэдээллийг 2026 оны 01 дүгээр улирлын байдлаар банкны программ болон хуулгатай тулган баталгаажууллаа.

Дүрслэл 7. Зээлийн эргэн төлөлт



2.2.8 “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 2 дугаар зүйлийн 2.2-т “Зээлдэгч зээлийн төлбөр (зээлийн үндсэн төлбөр, эсвэл хүүгийн төлбөр)-ийг 91 болон түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн бол хугацаа хэтэрсэн 91 дэх хоногоос зээлийн хүүгийн хөнгөлөлтийг зогсоох бөгөөд зээлийн хугацаа 181 хоног хэтэрсэн, эргэлтийн хөрөнгийн хэрэгцээг санхүүжүүлсэн, нэг зээлдэгчид нэгээс дээш банк давхардуулан энэхүү хөнгөлөлттэй зээл олгосон тохиолдолд хугацаагаар сүүлд олгосон зээлийн хүүгийн хөнгөлөлтийг цуцалж, зээлийн хүүгийн хөнгөлөлтгүй банкны энгийн нөхцөлтэй зээлд шилжүүлнэ” гэж заасан байна.

2.2.9 “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний хүрээнд зээл авсан зээлдэгчид нь Иргэний хуулийн 451 дүгээр зүйл болон арилжааны банкнуудтай байгуулсан зээлийн гэрээний хавсралт, эргэн төлөлтийн графикийн дагуу үндсэн зээл болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлөх үүрэг хүлээсэн байна.

2.2.10 Аудитаар банкнуудын зээлдэгчийн хувийн хэрэг, зээлийн дансны хуулга, зээлийн мэдээллийн сангийн өгөгдлийг газар дээр нь очиж тулган баталгаажуулахад 39,236.2 сая төгрөгийн зээлээс 662.6 сая төгрөгийн 21 зээлдэгч нь хугацаанаас нь өмнө урьдчилан хаасан бол 7,346.5 сая төгрөгийн зээлийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй байна.

2.2.11 “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 8 дугаар зүйлийн 8.2-д “Монгол банкны орон нутаг дахь нэгж “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн ашиглалт, зарцуулалтад зайны хяналт шалгалтыг хийнэ” гэж тусгасан байдаг.

2.2.12 Гэвч Монгол банкны орон нутаг дахь нэгжээс тус хөнгөлөлттэй зээлийн зарцуулалт, зориулалтад тусгайлан хяналт, шалгалт хийгдээгүй зөвхөн цахим хэлбэрээр буюу дансны хуулгаар нь хянаж ажилласан байна.

2.2.13 “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 8 дугаар зүйлийн 8.3-т “Зээлийн батлан даалтын сан “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавина” гэж заасан байдаг.

2.2.14 Аймгийн хэмжээнд 2024-2025 оны хугацаанд нийт 601 зээлдэгчийн 20,845.7 сая төгрөгийн зээлд 14,916.3 сая төгрөгийн батлан даалтыг олгохоор шийдвэрлэсэн байна.

2.2.15 Зээлийн батлан даалтын сангаас хоршооны төслийн хэрэгжилт, хоршооны гишүүн малчны батлан даалттай зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд 2024-2026 онуудад хийсэн хяналт, мониторингийн нэгдсэн мэдээг дараах байдлаар гаргасан байна.

Хүснэгт 3. ЗБДС-аас хяналт хэрэгжүүлсэн байдал

№	Он	Сумын тоо	Хоршооны тоо	Зээлдэгчийн тоо	Зарцуулалтын баримтаар	Газар дээр биечилсэн
1	2024	17	209	465	316	149
2	2025	4	8	20	0	20
3	2026	-	-	-	-	-
Нийт			217	485	316	169

2.2.16 Зээлийн батлан даалтын сангаас 2024 оны 11 дүгээр сарын 18-23-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Мандал сумаас бусад сумдад 3 ажлын хэсэг гарган нийт 155 хоршооны 333 малчны зээлийн материалд хяналт хийж, 58 малчны зээлийг газар дээр нь тулган баталгаажуулалт хийж ажилласан байна.


Гэвч тус ажлын хэсгийн тайланд зээлтэй холбоотой илэрсэн зөрчил дутагдлын талаар тусгаагүй байна.

2.2.17 Зээл олгосон банкнуудаас зээлийн эргэн хяналтыг олгосон тооцооны төвийн захирал, эдийн засагчид тайлант хугацаанд 1-3 удаа хийж, хяналтын хуудсыг хөтлөн, фото зургаар баталгаажуулсан байна.

2.2.18 Банкны төв салбараас зээлүүдийн зарцуулалтад хийх хяналтыг цахим хэлбэрээр буюу дансны хуулгаар нь хянаж ажилласан байна. Төрийн банкны салбарын захирлын баталсан удирдамжийн дагуу төв салбараас зээлийн ажилтнууд эргэн хяналтаар ажиллан зээлдэгч нартай уулзалт хийж, газар дээр нь очиж зарцуулалт, зориулалтыг хянаж шалгасан байна.

2.2.19 Хяналтын дагуу зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчилтэй 170.0 сая төгрөгийн 4 зээлдэгчийн зээлийг хаалгасан байна.

Дүрслэл 8. Зээлийн эргэн төлөлт



2.2.21 Хөнгөлөлттэй зээлийг олгож эхэлснээр малчид нийлж мах, сүү, ноос, ноолуураа дундын хоршоогоор дамжуулан анхан шатны ангилалт, боловсруулалт хийж үйлдвэрүүдэд шууд нийлүүлснээр ченжийн гар дамжилгүй, илүү өндөр үнээр борлуулах боломж бүрдсэн байна.

2.2.22 Зээлийн хөрөнгөөр хоршооны дундын фермер, өвөлжөө, тэжээлийн агуулах, худаг уст цэг байгуулах эсвэл өвс, тэжээл бэлтгэх техник хэрэгсэл /трактор, хадлангийн тоног төхөөрөмж/ худалдан авч, зардлаа хэмнэж, өвс, тэжээлээ намар улиралд хямд зардлаар их хэмжээгээр бэлтгэж нөөцөлснөөр зуд турхан, цаг агаарын хүндрэлийг хохирол багатай давах боломж бүрдсэн байна.

2.2.23 Гэвч иргэд зөвхөн зээл авахын тулд нэр бүхий хоршоо байгуулж, авсан зээлээ гишүүд нь хувааж авч хувийн хэрэгцээндээ ашиглах тохиолдол гарсан байна. Энэ нь хоршооны үндсэн зорилго болох жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж чадахгүй байх эрсдэлийг бий болгож байна.

2.2.24 “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь “Суурин барилга, байгууламж барих, өргөтгөх зориулалтаар хүсэлт гаргасан зээл хүсэгч нь өөрийн эсхүл хоршоо, хоршооны бусад гишүүний нэр дээр өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй газартай байх” гэсэн заалтын дагуу 110 өвөлжөө, хаваржаа, фермийн барилгыг шинээр барих, өргөтгөх болон засварлах зориулалтаар ашигласан байна.

2.2.25 Аудитаар нийт олгогдсон зээлүүдийн зээлдэгчийн хувийн хэрэгт хавсаргагдсан зарцуулалтын нотлох баримт, эргэн хяналтын тайлан зэргийг тулган шалгахад 1,959.0 сая төгрөгийн 89 зээлдэгчийн хувийн хэрэгт худалдах, худалдан авах гэрээгүй, зөвхөн дансны хуулга хавсаргаж хяналт хийсэн бусад нотлох баримтыг хавсаргаагүй зэрэг анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой зөрчил гарсан байна.

Энэ нь зээл олгогч банкнуудын эргэн хяналтын журмын холбогдох заалтуудыг зөрчсөн бөгөөд банк болон бусад хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын хяналтыг сулруулах, зээлийг зориулалтын дагуу зарцуулахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

2.2.26 Мөн 2 зээлдэгч нь зээлийн санхүүжилтээр хөрөнгө худалдан авахаар 56.0 сая төгрөгийг бусдад шилжүүлсэн боловч залилуулсан тул хуулийн байгууллагад хандсан байна.

2.2.27 Хөнгөлөлттэй зээл олгогдож эхэлснээр малын түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгох зах зээлийн судалгаа, борлуулалтын суваг нь тодорхой бус байснаас үүдэн тоног төхөөрөмж авсан ч ажиллуулж чадахгүй байх зэрэг эрсдэл үүсэж, трактор, хадлангийн тоног төхөөрөмж, мах сүүний чиглэлийн малын үнэ эрс нэмэгдэх зэрэг сөрөг нөхцөл байдлыг бий болгосон байна.

2.2.28 Шинэ хоршоо хөдөлгөөний зээл нь зорилгоо зөв тодорхойлж, хамтын хөдөлмөрөө бодитоор зохион байгуулж чадсан зарим малчдын хувьд орлогоо өсгөх, эрсдэлээ багасгах маш том үр дүнтэй хөшүүрэг болсон. Үүнийг жишээгээр дурдвал:

- Мандал сумын “Эко дүүрэн бороо” хоршоо нь нийт 110.0 сая төгрөгийн зээл авч мал эмнэлэг болон жижиг эрдэст тэжээлийн үйлдвэр байгуулсан,
- Хушаат сумын “Шинэстэй шимт мах” хоршоо нийт 194.0 сая төгрөгийн зээл авч малын эрчимжсэн фермер байгуулан, хоршооны нэрийн брэнд мах, цагаан идээг гарган үйлдвэрлэл эрхэлж эхэлсэн,
- Жавхлант сумын “Мөнхөд баялаг ундарга” хоршоо нь нийт 150.0 сая төгрөгийн зээл авч, тэжээлийн ургамал, эрдэнэ шиш тариалах, тэжээл бэлтгэх тоног төхөөрөмж авч үйл ажиллагаагаа эхлүүлсэн,
- Алтанбулаг сумын “Цөх баян төхөм” хоршоо нь нийт 430.0 сая төгрөгийн зээл авч 35*10 хэмжээтэй үхрийн фермер барьж, худаг гарган, хадлангийн тоног төхөөрөмж бэлтгэсэн зэрэг.

Дүрслэл 9. Хоршоогоор нийлж хийсэн үр дүн бүхий бүтээн байгуулалтууд



2.2.29 Тус хөнгөлөлттэй зээл хэрэгжиж эхэлснээр зээлд хамрагдсан малчин иргэдэд дараах хөрөнгүүд бий болсон байна. Үүнд:

- 183 ширхэг хадлангийн иж бүрэн техник,
- мах сүүний чиглэлийн 2850 үхэр, сайн үүлдрийн 36 бух,
- эдельбай үүлдрийн 10 хуц,
- 1245 эм хонь худалдан авч
- 110 ширхэг өвөлжөө шинээр барих болон засварлаж,
- 21 худаг гаргасан,
- 22 хоршоо өөрийн болон түрээсийн талбайд тэжээл тариалсан.
- 20 хоршоо ачааны машин авсан.
- 30 хоршоо нь мах сүү, арьс, тэжээл боловсруулах тоног төхөөрөмж авах, махны дэлгүүр, мах бордох байр, тэжээлийн хашаа барихад зээлээ зарцуулсан байна.

2.2.30 “Шинэ хоршоо-чинээлэг малчин” үндэсний хөдөлгөөний хүрээнд олгогдсон хөнгөлөлттэй зээл нь хоршооны үйл ажиллагааг дэмжих үндсэн зорилтоо хангаагүй боловч малчин иргэдийн амьдралд нөлөө бүхий үр дүнг үзүүлж чадсан байна.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газарт уламжлах нь:

- “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээнд Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-ийн “Малчны тодорхойлолт”-ыг үндэслэнэ гэсний дагуу банкнууд нь зээл олгосон байна. Гэвч Үндэсний статистикийн хорооны 1212.mn цахим системээс авсан мэдээллээр “мал бүхий иргэн”-ээр 80 зээлдэгч бүртгэлтэй байна. Иймд Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-ээс гарч буй “Малчны тодорхойлолт”-ыг үнэн зөв гаргуулах шаардлагатай байна.

Аудитаар илэрсэн нийт **1,959.0** сая төгрөгийн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв. Үүнд:

- УБХ нь мэдээллийн санд 2 хоршооны дүрмийн санг илүү дүнгээр бүртгэсэн байна.
- Зээлдэгчийн хувийн хэрэгт хавсаргагдсан эргэн хяналтын тайланд зарцуулалтын 1,959.0 сая төгрөгийн 89 зээлдэгчийн анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан шалгуур үзүүлэлт, санхүүжилтийг бүрэн, бодитой төлөвлөөгүйгээс хэрэгжилтийн үр нөлөө төлөвлөсөн түвшинд хүрээгүй байна.
- “Шинэ хоршоо – чинээлэг малчин арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгасан арга хэмжээний хүрэх түвшин шаардагдах хөрөнгийг бодитой тооцоогүй байна.
- Хоршоонд бус малчинд чиглэсэн зээлийн бодлого, шалгуур үзүүлэлтийн дутагдалтай байдлаас үүдэн зээлийн шаардлага хангах зорилготойгоор нэгдсэн хэлбэр төдий анхан шатны хоршоодыг бий болгосон байна.
- Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоод нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан боловч хуулийн хугацаанд санхүүгийн тайланг гаргаагүй, бүртгэл хөтлөлт хангалтгүй байгаа нь үйл ажиллагааны үр дүнг бодитой үнэлж, дүгнэх боломжгүй байдалд хүргэж байна.
- Банкны шалгуур хангасан малчдад хөнгөлөлттэй зээлийг олгосон хэдий ч зээлийн зарцуулалт, ашиглалт болон эргэн төлөлтийн явцад үр нөлөө бүхий хяналтыг холбогдох байгууллагуудаас хийгээгүй байна.

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга /Н.Лхагвадорж/-д:

- Хоршооны үйл ажиллагаанд хяналт хийх эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагааг сайжруулах, үр дүнтэй хяналт хэрэгжүүлэх, хөнгөлөлттэй зээлийн зарцуулалтын үр дүнг тооцох,
- Хоршооны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-25.4, 27.1 дэх заалтуудыг үндэслэн хоршоодын санхүүгийн тайланд үнэн зөв тусгуулах ажлыг зохион байгуулах,
- Аймгийн хэмжээнд бүртгэлтэй хоршоодын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд хүлээн авч, ирүүлээгүй хоршоодод Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах,

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга /Б.Саранчимэг/-т:

- Улсын бүртгэлийн мэдээллийн санд 2 хоршооны дүрмийн санг зөрүүтэй бүртгэсэн зөрчлийг залруулах,

Төрийн болон ХААН банкны Сэлэнгэ салбарын захирал нарт:

- Олгогдсон хөнгөлөлттэй зээлүүдийн явцын эргэн хяналтын чанарыг сайжруулах, зээлийн ашиглалт нь бизнес төлөвлөгөөтэй уялдаж байгаа эсэхэд хяналт хийх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР


АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР



Б.БАТМӨНХ

Т.БОЛОР

Ж.ЦОГТ

Б.НАРАНЦЭЦЭГ

Ж.БАЯСГАЛАН

Э.ЭНХБҮРЭН

Р.ОТГОНЖАРГАЛ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ИРҮҮЛСЭН САНАЛ




**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын I байр, Их суварга 505,
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг 43081
Утас: Факс: 7036-2223, Цахим шуудан: azdtg@selenge.gov.mn
Цахим хуудас: www.selenge.gov.mn

2026.06.30 № 01/785
танай _____-ны № _____

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүнгийн талаар хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Уг тайлантай холбогдуулан өгөх санал, хүсэлт байхгүй болно.


Н.ЛХАГВАДОРЖ

C:\user\2026\Засаг дарга жижиг тоот А5

4326090968

БАНКНУУДААС ИРҮҮЛСЭН САНАЛ



ТӨРИЙН БАНК

СЭЛЭНГЭ САЛБАР

43080, Сэлэнгэ аймаг Сүхбаатар сум

6-р баг Төрийн банкны Төв байр

Утас: 70363635, 70363080 Факс: (976-11) 319044

И-мэйл: s1500@statebank.mn

Вэбсайт: www.statebank.mn, Лавлах төв: 1800-1881

2026.06.30 № 32/496
Танай _____-ны № _____-т

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР-Т**

Төрийн банкны Сэлэнгэ салбар “Шинэ хоршоо хөдөлгөөнд олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцсан болно.

Тайлангийн төсөлтэй танилцаж, холбогдох саналгүй болно.

САЛБАРЫН ЗАХИРАЛ



П.БАТТӨР

320000000414



ХААН БАНК

ХХД-9007001013
СЭЛЭНГЭ САЛБАР
Сэлэнгэ аймаг,
Сүхбаатар сум, 6-р баг

Утас: (976)-70362189
www.khanbank.com

2026 оны 06 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 5675/26/0694

Сэлэнгэ аймаг

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БАТМӨНХ-д

Албан тоотын хариу

СЭА-2026/21/17-ШТА-ГА дугаартай аудитын тайлантай танилцлаа. ХААН Банкны Сэлэнгэ салбарын зүгээс хариу тайлбаргүй. Аудитын тайланд дурьдагдсан зөвлөмжийн дагуу хяналтыг сайжруулж ажиллана.

Хамтран ажилласанд баярлалаа.



САЛБАРЫН ЗАХИРАГЧИЙН

Н.ТӨРМӨНХ

26-4893



ТӨРИЙН БАНК

ЗҮҮНХАРАА САЛБАР

43030, Сэлэнгэ аймаг, Мандал сум, 7-р баг

Худалдааны гудамж, 9-922 тоот

Утас: 70367000 Факс: (976-11) 319044

И-мэйл: s1401@statebank.mn

Вэбсайт: www.statebank.mn, Лаллах төв: 1800-1881

2026 06 30

№

30/165

Танай

-ны №

-т

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Танай 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 303
тоот албан бичгээр ирүүлсэн “Шинэ хоршоо”
хөдөлгөөний хүрээнд олгосон зээлийн тайлангийн
төсөлтэй танилцлаа.

Нэмэлт санал, тайлбар байхгүй болно.

ЗАХИРАЛ ТӨРИЙН БАНК АДАШДЭЛГЭР



433040220



ХААН БАНК

ХХД-9607001013
ЗҮҮНХАРАА САЛБАР
Сэлэнгэ аймаг,
Мандал сум, 3-р баг
Утас: 976-75153333-2050
www.khanbank.com

2026 оны 06 дугаар
сарын 30-ны өдөр

5001/26/468

Сэлэнгэ, Мандал сум

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

2026 оны 06 сарын 26-ны өдрийн
албан тоотын хариу:

“Шинэ хоршоо хөдөлгөөнд олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн
аудитын тайлантай танилцсан. Тайлантай холбоотой санал хүсэлт байхгүй болно.

САЛБАРЫН ЗАХИРАЛ



Б.УУГАНБАЯР